



I-III/2022

Тархаасан: 2022 оны 5 дугаар сарын 16



Барилга угсралт, их засварын ажил 2022 оны эхний улиралд 1.4 хувиар буурлаа

Барилга угсралт, их засварын ажил 2022 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 564.9 тэрбум төгрөг болж, 560.9 (99.3%) тэрбум төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 4.0 (0.7%) тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна.


ХҮСНЭГТ 1. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, гүйцэтгэгчийн төрлөөр, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар

	2019 I-III	2020 I-III	2021 I-III	2022* I-III	<u>2022* I-III</u> 2021 I-III
	тэрбум төгрөг				хувь
Нийт	426.6	589.5	573.1	564.9	98.6
Дотоодын байгууллага	416.2	583.4	568.6	560.9	98.6
Төрийн	1.5	7.3	78.7	17.4	22.2
Хувийн	412.1	575.0	480.0	535.9	111.7
Гадаадтай хамтарсан	2.6	1.1	9.9	7.5	75.9
Гадаадын байгууллага	10.4	6.1	4.5	4.0	88.0

Барилга угсралт, их засварын ажил 2022 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 8.2 (1.4%) тэрбум төгрөгөөр буурахад төрийн байгууллагын барилгын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 61.3 (77.8%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлөв.

Харин дотоодын барилгын байгууллагаас хувийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 535.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 56.0 (11.7%) тэрбум төгрөгөөр өссөн хэдий ч төрийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 17.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 61.3 (77.8%) тэрбум төгрөгөөр, гадаадтай хамтарсан байгууллагынх 7.5 тэрбум төгрөг болж, 2.4 (24.1%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

ЗУРАГ 1. БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар, төрлөөр, тэрбум төгрөг



Энэ оны эхний улиралд барилга угсралт, их засварын ажлын 51.2 хувийг орон сууцны барилга, 38.1 хувийг орон сууцны бус барилга, 8.5 хувийг инженерийн барилга, байгууламж, 2.2 хувийг их засварын ажил эзэлж, өмнөх оны мөн үеэс орон сууцны барилгын ажлын эзлэх хувь 14.9 нэгж хувиар өссөн бол инженерийн барилга, байгууламжийнх 9.2 нэгж хувиар, орон сууцны бус барилгынх 6.2 нэгж хувиар тус тус буурсан байна.


ХҮСНЭГТ 2. ОРОН СУУЦНЫ БУС БАРИЛГА, төрлөөр, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар

	2019 I-III	2020 I-III	2021 I-III	2022* I-III	$\frac{2022^* \text{ I-III}}{2021 \text{ I-III}}$
	тэрбум төгрөг				хувь
Орон сууцны бус барилга	288.3	319.9	253.8	215.2	84.8
Үйлдвэрийн	201.3	133.5	167.3	120.5	72.0
Худалдаа, үйлчилгээний	13.2	20.0	15.9	28.4	178.3
Эмнэлгийн	14.8	12.3	6.7	6.8	101.3
Сургууль, соёлын	37.8	58.0	39.8	30.0	75.4
Бусад	21.1	96.2	24.1	29.5	122.4

Орон сууцны бус барилгын ажил 2022 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 215.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 38.6 (15.2%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд худалдаа, үйлчилгээний барилгын ажил 12.5 (78.3%) тэрбум төгрөгөөр, бусад орон сууцны бус барилгынх 5.4 (22.4%) тэрбум төгрөгөөр, эмнэлгийн барилгынх 87.3 (1.3%) сая төгрөгөөр өссөн хэдий ч үйлдвэрийн барилгынх 46.8 (28.0%) тэрбум төгрөгөөр, сургууль соёлын барилгынх 9.8 (24.6%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

ЗУРАГ 2. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, тэрбум төгрөгөөр

- Улаанбаатар хотод гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил
- Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил



Улаанбаатар хотод 2022 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 346.5 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэн нь улсын дүнд 61.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 14.4 нэгж хувиар өссөн байна.

Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2022 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр

Өмнөговь аймагт 144.9 тэрбум төгрөг, Орхон аймагт 18.3 тэрбум төгрөг болж, энэ нь аймгуудын барилга угсралтын ажлын дүнд 76.1 хувийг эзэлж байна. Эдгээр аймгийн нутаг дэвсгэрт төмөр замын болон Эрдэнэт үйлдвэрийн барилгын өргөтгөлийн барилга угсралтын ажил эрчимтэй явагдаж байна.

Ойлголт, тодорхойлолт

Барилга угсралт, их засвар гэж барилга байшин барих болон инженерийн зориулалтаар зам, гүүр, далан зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагааг ойлгоно.

Орон сууцны барилга нь хамгийн багадаа түүний тал хэсгийг нь орон сууцны зориулалтаар ашигладаг байгууламж юм.

Орон сууцны бус барилгад барилгын багахан хэсгийг (нийт талбайн 50%-иас бага хэсэг) орон сууцны зориулалтаар ашигладаг барилгыг оруулна.

Инженерийн барилгын ажилд төмөр зам, зам, гүүр, хурдны зам, онгоцны буудлын талбай, ус хангамж, бохирын шугам, далан хаалт, усжуулалтын байгууламж зэрэг барилга угсралтад ангилагддаггүй барилга байгууламжийн бүх ажлыг оруулна.



Тайлбар: ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл

Эх үүсвэр:

ҮСХ, Барилга байгууламж, объектын улирлын мэдээ (ББО-1)

Ангилал, код:

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 4.0

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 8 дугаар сарын 13

Эдийн засгийн статистикийн газрын дарга

А.Дэмбэрэл

Утас : (976-51)-329271

Эдийн засгийн статистикийн газрын Хөдөө

аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэлийн

статистикийн хэлтсийн статистикч

Л.Шинэтуяа

Утас : (976-51)-261563



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212